

**СҮМБЭР СУМЫН 2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ,
САНАЛ БАРАГДУУЛАЛТЫН ТАЙЛАН**

/өссөн дүнгээр/

2024.09.25

Сүмбэр

2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар Сумын Засаг дарга түүний Тамгын газарт нийт 271 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн.

Ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл:

- 1.Албан хаагчдын хүсэлт-11
- 2.Газар хүссэн -175
- 3.Тусгай зөвшөөрөл -4
- 4.Мөнгөн дэмжлэг хүссэн-10
- 5.Төрийн алба хаагчийн байр хүссэн-12
- 6.Үйл ажиллагааны дэмжлэг хүссэн-2
- 7.Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой-1
- 8.Нүүрсний дэмжлэг хүссэн-1
- 9.Өвс тэжээлийн дэмжлэг хүссэн-2
- 10.Нохой муурын устгалтай холбоотой-2
- 11.Ахмадын байр хүссэн-1
- 12.Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой-2
- 13.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх тухай-3
- 14.Хүлэмж хүссэн-1
- 15.Худгийн зөвшөөрөл хүссэн-3
- 16.Модны урамшуулалд хамрагдахыг хүссэн-9
- 17.Харгалзан дэмжигч, Асран хамгаалагч тогтоох тухай-15
- 18.Үрчлэлтэй холбоотой-3
- 19.Гэр хүссэн-7
- 20.Бусад-7
21. Малын тоо толгойн албан татвараас чөлөөлөх тухай-7
- 22.Орчны цэвэрлэгээ тохижилт бүтээн байгууллацтай холбоотой-3
- 23.Малын тооллоготой холбоотой гомдол-1

1.Газар хүссэн 175 өргөдлийн мөрөөр авч үзвэл дээрх ирүүлсэн хүсэлтүүдийг хүлээн авч хадлан хадах зөвшөөрөл хүссэн 14 өргөдөл ирсэн уг хүсэлтийг Сумын Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/200 тоот захирамжаар

зөвшөөрөл олгон холбогдох иргэн, аж ахуйн нэгж, хоршоодоод харицг хүрүүлж ажиллсан.

Газрын эзэмших эрхийг өмчлөх эрхээр солих хүсэлт ирүүлсэн 8 өргөдлийг Сумын Засаг даргын захирамжар шийдвэрлэн хариуг иргэнд цаасаар хүргүүлсэн.

Газрын эзэмших өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх 5 өргөдлийг Сумын Засаг даргын захирамжаар шийдвэрлэн иргэнд цаасаар хүргүүлсэн.

Газрын хэмжилт хийлгэх хүсэлт ирүүлсэн 3 иргэний өргөдлийн дагуу хэмжилт хийн 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/402, 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/561, 562 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.

Газрын эрхийн хугацааг дуусгавар болгохоор ирүүлсэн 1 иргэний өргөдлийг хүлээн авч 2024 оны 05 дугаар сарын 31-ний А/138 тоот захирамжаар газар эзэмших эрхийн хугацааг дуусгавар болгон хүргүүлсэн.

Газрын эрх өөрчлүүлэхийг хүссэн 1 иргэний хүсэлтийг хүлээн авч Сүмбэр сумын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар оруулан хэлэлцүүлсэн бөгөөд тус иргэний газар инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас газартай давхацсан тул дэмжигдээгүй болно. Иргэнд хариуг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/205 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.

1 иргэний газар эзэмшихээр ирүүлсэн өргөдөл нь инженерийн шугам сүлжээтэй давхцаж байгаа тул шийдвэрлэх боломжгүй дахин өөр газарт санал ирүүлэхийг зөвлөн ажиллаж байна.

Газар эзэмшихээр ирүүлсэн 2 иргэний өргөдлийг хүлээн авч 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд тухай иргэдэд албан бичгээр хариуг хүргүүлсэн болно.

Хоршооны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор-8 иргэн, хүнсний ногоо тарих зориулалттайгаар газар хүссэн-5 иргэн, Эрчимжсэн мал аж ахуйн бүсэд газар хүссэн-4 иргэн, гэр бүлийн зориулалтаар 0,07 га газар эзэмших хүсэлт гаргасан-112 иргэн, газрын эрх шилжүүлэх хүслэт гаргасан-1 иргэн, газрын эрх өөрчлөх тухай хүсэлт гаргасан-3 иргэн, газрын хэмжээ сунгахыг хүссэн 3 иргэний өргөдөл тус бүр ирсэн бөгөөд эдгээр өргөдлийг Сүмбэр сумын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн эцсийн төлөвлөгөөнд оруулан хэлэлцүүлэхээр бэлтгэл хангаж ажиллаж байна.

2.Тусгай зөвшөөрөл -3 өргөдлийн мөрөөр авч үзвэл тамхины тусгай зөвшөөрөл сунгуулахаар 2 аж ахуй нэгж өргөдөл ирүүлсэн бөгөөд сумын Засаг даргын А/152, А/153 тоот захирамжаар тус бүр 2 жилийн хугацаатайгаар тамхи худалдан борлуулах сунгалтыг хийв. Мөн цахим тоглоомын газар ажиллуулахаар ирүүлсэн 1 иргэний хүсэлтийг хүлээн авч холбогдох байгууллагад холбон зуучлах үйлчилгээ үзүүлж ажилласан.

3.Мөнгөн дэмжлэг хүссэн-9 хүсэлт ирснийг бүртгэлд авч бүртгэлжүүлэн удирдлагын цохолтоор холбогдох албан хаагчдад хүргүүлсэн. Дэмжлэг хүссэн нийт өргөдөл, хүсэлтийг Сумын Засаг даргын 2024.02.05 А/54, 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/87, 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн А/221 тоот захирамжуудаар шийдвэрлэн нийт 16.100.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

4.Төрийн албан хаагчийн байрны дэмжлэг хүссэн нийт 12 төрийн албан хаагчийн ирүүлсэн өргөдлийг Аймгийн Засаг даргын Тамгын газарт уламжлан өгч нийт 7 төрийн албан хаагчийг орон байраар хангаж ажиллаа.

5.Үйл ажиллагааны дэмжлэг хүссэн-2 өргөдөл ирснийг хүлээн авч нөхцөл байдалтай танилцах, орчныг сайжруулах тал дээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллаж байна. Сүмбэр гардэн дээр худалдаа үйлчилгээ эрхлэх хүсэлт ирүүлсэн 1 иргэний өргөдлийг хүлээн авч Тохижилт сүмбэр орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрлэлийн газартай холбон зуучилж ажилласан бөгөөд тус иргэн нь одоогоор сүмбэр гардэн цэцэрлэгт хүрээлэн дээр худалдаа эрхлэн ажиллаж байна.

6.Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой-1 өргөдөл ирснийг хүлээн авч танилцан тухайн иргэн Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээлээ төлөөгүйн улмаас шүүхийн шийдвэр гүйцэтгүүлж байсан бөгөөд уг иргэнтэй хамтран тохиролцож төлөх хугацааг товлон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллаа.

7.Нүүрсний дэмжлэг хүссэн 1 иргэн хүсэлт өгсөн бөгөөд тухайн иргэн өөрийн өрхөд малтай мал нь Дорноговь аймгийн Иххэт сумын 2 дугаар багийн харьяат байсан бөгөөд уг иргэн өөрөө албан ёсоор тус суманд шилжиж ирээгүй тул уг өргөдлийг шийдвэрлэх боломжгүй талаар иргэнтэй уулзаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж өөрийн биеэр Сүмбэр сумын 2 дугаарт багт шилжиж ирэх хэрэгтэй талаар мэдээлэл өгч ажиллаа.

8.Өвс тэжээлийн дэмжлэг хүссэн 2 иргэнийн өргөдлийг хүлээн авч нийт 6 боодол өвс олгож ажиллаа.

9.Нохой муурын устгалын талаарх ирүүлсэн 2 иргэний хүсэлтийг хүлээн авч Аймгийн цагдаагийн хэлтэстэй хамтран тухайн нохойны эздэд санамж мэдүүлэг өгч ажиллаа.

10.Сумын ахмадын хорооноос ирүүлсэн орон байраар хангах өргөдлийг хүлээн авч ажилласан бөгөөд тус байранд засварлах ажлыг гүйцэтгэж байна.

11.Хөдөөгийн 6 дугаар багийн иргэдээс цас их орж зам харгуй хаагдсантай холбогдуулан ирүүлсэн өргөдлийг хүлээн авч техник хүч хэрэгслээр тусламж дэмжлэг үзүүлэн ажиллаа.

12.Байгаль орчин нөлөөлөх нөхцөл байдлын үнэлгээ хийлгэхээр ирүүлсэн 3 өргөдлийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/310, А/311, 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/529 тоот албан бичгээр дэмжих бичиг үйлдэн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлэн ажиллаа.

13.Хүлэмж хүссэн 1 өргөдлийг хүлээн авсан бөгөөд хүлэмжээр хангаж ажиллаа.

14.Худгийн зөвшөөрөл хүссэн 3 иргэний өргөдөл ирүүлсэн бөгөөд 2 иргэнд дэмжих бичиг хийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлж ажилласан болно. Мөн 2 дахь иргэний ирүүлсэн өргөдөл нь төсвийн мөнгөөр худаг гаргуулах хүсэлт байгаа бөгөөд 2024 оны төсөвт уг асуудлыг шийдвэрлэх төсөв байхгүй байгаа бөгөөд 2025 оны төсөвт тусган ажиллахаар төлөвлөсөн байна.

15.Модны урамшуулалд хамрагдах хүсэлтийг 9 иргэн ирүүлснийг Байгаль орчин аялал жуулчлалын газарт 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/529 тоот бичгээр хүргүүлэн ажиллаж байна.

16.Харгалзан дэмжигч, асран хамгаалагчаар тогтоох тухай хүсэлт 15 иргэн ирүүлсэн байгаа бөгөөд тус хүсэлтүүдийг сумын Засаг даргын А/04, А/05, А/02, А/95, А/78, А/89, А/70, А/160, А/161, А/162, А/164 тоот захирамжуудаар гарган хариуг тухайн иргэнд нь эх хувиар нь хүргүүлэн ажилласан. Шинээр нэмэгдэн ирсэн 3 иргэний хүсэлтийн дагуу дутуу материалыг бүрдүүлэн ажиллаж байна.

17. Үрчлэлтэй холбоотой 3 хүсэлт ирсэн байгаа бөгөөд тус иргэдийн материалыг холбогдох хууль журмын авч хэлэлцэн сумын Засаг даргын А/03, А/31, А/94 тоот захирамжуудаар гаргаж холбогдох этгээдэд хүргүүлэн ажиллав.

18.Гэр хүссэн 7 иргэнээс өргөдөл ирүүлсэн байгаа бөгөөд Аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэн иргэдэд гэр олгон ажиллаа.

19. Малын тоо толгойн албан татвараас чөлөөлөх тухай өргөдлийн Сүмбэр сумын 4, 5, 6 дугаар багийн малчин бүлгүүд ирүүлсэн бөгөөд тухайн 7 бүлгээс ирүүлсэн өргөдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу судлан саналыг боловсруулж Аймгийн Татварын газарт өргөдлийн эх хувиар нь шилжүүлсэн байна.

20.Бусад чиглэлээр 7 өргөдөл байгаа бөгөөд үүнээс:

Замын орц гарц чөлөөлүүлэхээр ирүүлсэн 1 иргэний материалыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс рүү шилжүүлсэн.

Цахилгаан шугам сүлжээнд холбогдохоор ирүүлсэн 1 иргэний өргөдлийн Цахилган түгээх үндэсний сүлжээ компанийн Говьсүмбэр салбарт хүргүүлэн техникийн тодорхойлолт нөхцөл байдлын тусламж хүсэн шилжүүлсэн байна

Сэг зэм устгах ажлын чиглэлээр 5 иргэнээс хүсэлт ирүүлсэн бөгөөд 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 04 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл Сүмбэр сумыг хэмжээнд сэг зэм устгах, булах, ариутгах ажлыг зохион байгуулж ажилласан бөгөөд ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна.

2023 оны малын тооллоготой холбоотой 1 иргэн хүсэлт ирүүлсэн бөгөөд тус айлын мал нь малыг программд шивэгдээгүй байсан.уг асуудлаар аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэст хүсэлтийг хүргүүлэн иргэний малыг малын прораммд шивж оруулсан.

Орчны цэвэрлэгээ гадна тохижилттой холбоотой Ганзам багийн оршин суугчдаас 3 хүсэлт ирсэн бөгөөд уг хүсэлтийн дагуу Чойр хотын Захирагчийн ажлын албаны албан хаагчид Сумын Засаг дарга Тохижилт сүмбэр ОНӨААТҮГын албан хаагчид Ганзам багийн ойр орчмыг цэвэрлэх, хогийн сав байршуулах зэрэг тохижилтыг ажлыг хийж гүйцэтгэлээ.

2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар ирсэн өргөдөл гомдол шийдвэрлэлт 98,2 хувьтай байна.

ТАЙЛАН БИЧСЭН:
АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ
ХАРИУЦСАН АЖИЛТАН

Д..ХИШИГЦЭЦЭГ

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

П.НАРАНМАНДАХ

